



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА САНДАГИЙН БЯМБАЦОГТ
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ганзоригийн ТЭМҮҮЛЭН

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-29-94, Факс: 32-70-16
E-mail: temuulen@parliament.mn
http://www.parliament.mn

2026.06.10 № УИХ-03/6738
танай _____-ны № _____-т


Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг санаачлан боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцүүлж өгөхийг хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



Г.ТЭМҮҮЛЭН

Н.АЛТАНХУЯГ

Т.АУБАКИР

М.БАДАМСҮРЭН

Д.БАТБАЯР

Р.БАТБОЛД

Ж.БАТЖАРГАЛ

Ж.БАТСУУРЬ

Ж.БАТ-ЭРДЭНЭ

Ж.БАЯРМАА

Ж.БАЯСГАЛАН

00013

ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНДАН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

НЭГ. Асуудалд дүн шинжилгээ хийх

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Улсын Их Хурал төрийн дотоод, гадаад бодлогын аль ч асуудлыг санаачлан хэлэлцэж болох бөгөөд дараах асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ: ...7/ төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлого, үндсэн чиглэлийг тодорхойлж, хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцүүлэн боловсруулсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг батлах; Хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна. Улсын төсвийг хэлэлцэн батлахдаа төсвийн орлого, зарлагын бүтцийг өөрчилж болно. Ингэхдээ Засгийн газрын өргөн мэдүүлсэн төсвийн зарлагын болон алдагдлын хэмжээг нэмэгдүүлж үл болно.” гэж заасан.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 8 дугаар зүйлд Эдийн засгийн хөгжил, шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого боловсруулж хэрэгжүүлэх талаархи Засгийн газрын бүрэн эрхийг тодорхойлохдоо 8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Хөгжлийн зорилтот хөтөлбөр, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө болон улсын төсвийг боловсруулахад Засгийн газраас баримтлах үзүүлэлтүүдийн хязгаар, үндсэн тэнцвэрийг тодорхойлсон төсвийн хүрээний мэдэгдлийг Монгол Улсын Үндсэн хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.”, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Улсын төсвийн төслийг Улсын Их Хурлаас баталсан урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхэд чиглэсэн Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэн боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, гарсан шийдвэрийг хэрэгжүүлнэ.” гэж тус тус заасан.

Монгол Улсын Үндсэн хуулиар төсөв нь Монгол Улсын хөгжлийн бодлогод туссан зорилго, зорилтыг санхүүжүүлэхэд чиглэсэн байхыг тодорхой заажээ. Харин, Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд заасны дагуу төсвийн хүрээний мэдэгдлийг Монгол Улсын Үндсэн хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу боловсруулах ба уг баримт бичиг нь Засгийн газраас баримтлах үзүүлэлтүүдийн хязгаар, үндсэн тэнцвэрийг тодорхойлсон байхыг заасан байна. Өөрөөр хэлбэл, төсвийн хүрээний мэдэгдэл нь төсвийн орлого, зарлагын бодит тэнцлийг илэрхийлсэн байхыг хууль тогтоомжийн хүрээнд тодорхой дурджээ.

Дээрх хуулийн зохицуулалтуудыг дүгнэвэл, хөгжлийн бодлогод туссан зорилго, зорилтыг хангахад чиглэсэн төсөв нь Засгийн газраас баримтлах үзүүлэлтүүдийн хязгаар, үндсэн тэнцвэрт нийцсэн байх шаардлагатай байна. Хөгжлийн бодлого нь төсөвтэй байх, төсөв нь бодитой хэрэгжихүйц байх буюу санхүүжүүлэх боломжтой байхын тулд Засгийн газрын бодлого, шийдвэрийн үр дүн нь өнөө болон ирээдүйн үед сөрөг үр дагавар үлдээх учиргүй. Энэ ч агуулгаар Монгол Улс төсөвт баримтлах зарчим, тусгай шаардлагыг бий болгон үүнийгээ Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд тус тус хуульчлан баталсан.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтад ““төсвийн тусгай шаардлага” гэж нэгдсэн төсвийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн, төсвийн богино, дунд, урт хугацааны бодлого, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг тодорхойлоход баримтлах, энэ хуулиар тогтоосон зохистой үзүүлэлтийн түвшин, харьцаа, хязгаарлалтыг;” гэж заасан

Мөн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.11 дэх заалтад ““нэгдсэн төсөв” гэж Төсвийн тухай хуулийн 21.1-т заасныг; Төсвийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэгт “Монгол Улсын нэгдсэн төсөв нь улсын төсөв, орон нутгийн төсөв, Ирээдүйн өв сангийн төсөв, Үндэсний баялгийн сангийн төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвөөс бүрдэнэ.” гэж заасан.

Монгол Улс Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг 2010 оны 06 дугаар сарын 24-ний өдөр баталж, төсвийн бодлогод баримтлах суурь зарчим, төсвийн тусгай шаардлагыг хэрэгжүүлэхээр заасан. Гэвч хууль баталснаас хойш төсвийн тусгай шаардлагын үйлчлэх хугацааг хойшлуулах, эсхүл агуулгыг өөрчлөх шинжтэй нийт 10 удаагийн нэмэлт, өөрчлөлт хийсэн байна. Өөрөөр хэлбэл, өнөөдрийг хүртэл Монгол Улс төсвийн тусгай шаардлагыг хангуулж ирсэн төсвийн жил хуруу дарам цөөхөн байна. Төсвийн тусгай шаардлагын өөрчлөлтийг харуулбал:

2010-10-03	2015-01-20	2015-12-08	2015-05-21	2016-09-09
6.1.1.нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцдог байх				
6.1.2.нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний 2 хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байх				
6.1.3.тухайн жилийн нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь нь тухайн жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн хувь, тухайн жилийн өмнөх дараалсан 12 жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн дунджийн аль ихээс хэтрэхгүй байх.				
6.1.4.уул уурхайн салбарын гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн дүрмийн санд оруулах зориулалттай бөгөөд тухайн хуулийн этгээдийн ирээдүйн ашгаас эргэн төлөгдөх нөхцөлтэй байгуулсан гэрээний дагуу авсан Засгийн газрын зээл, эсхүл гэрээний энэхүү нөхцөлөөр гаргасан Засгийн газрын баталгааг хамааруулахгүйгээр тооцсон улсын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний 40 хувиас хэтрэхгүй байх		"6.1.4.Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний 40 хувиас хэтрэхгүй байх." 6.2.Энэ хуулийн 6.1.4-т заасан Засгийн газрын өрийн хязгаар нь уул уурхайн салбарын хуулийн этгээдэд Засгийн газар хувь нийлүүлсэн хөрөнгө оруулах зориулалттай бөгөөд тухайн хуулийн этгээдийн ашгаас эргэн төлөгдөх нөхцөлтэй байгуулсан гэрээний дагуу авсан Засгийн газрын зээл, эсхүл гэрээний энэхүү нөхцөлөөр гаргасан Засгийн газрын баталгаанд хамаарахгүй. 6.3.Энэ хуулийн 6.1.4-т заасан Засгийн газрын өрийн хязгаарт Засгийн газрын дотоод үнэт цаасаар бүрэн баталгаажсан буюу барьцаа тавьсан өрийн баталгааны үлдэгдлийг оруулж тооцохгүй."	6.2 дахь хэсгийн "уул уурхайн" гэсний өмнө "эрчим хүч, төмөр зам," гэж нэмсүгэй	6.1.4.Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний 60 хувиас хэтрэхгүй байх."
19.1. энэ хуулийн 6.1.2, 6.1.3-т заасан төсвийн тусгай шаардлагыг 2013 оны төсвийн жилээс эхлэн дагаж мөрдөнө.	"19.1.Энэ хуулийн 6.1.2-т заасан төсвийн тусгай шаардлагыг 2018 оны төсвийн жилээс, энэ хуулийн 6.1.3-т заасан төсвийн тусгай шаардлагыг 2013 оны			"19.1.Энэ хуулийн 6.1.2-т заасан төсвийн тусгай шаардлагыг 2020 оны төсвийн жилээс, энэ хуулийн 6.1.3-т заасан төсвийн тусгай шаардлагыг 2017 оны төсвийн жилээс эхлэн тус тус дагаж мөрдөнө.

	төсвийн жилээс эхлэн тус тус дагаж мөрдөнө."			
19.2.Энэ хуулийн 6.1.4-т заасан төсвийн тусгай шаардлагыг 2014 оны төсвийн жилээс эхлэн дагаж мөрдөнө.	19.2 дахь хэсгийн "2014 оны" гэснийг "2018 оны" гэж			19.2.Энэ хуулийн 6.1.4-т заасан тусгай шаардлагыг 2021 оны төсвийн жилээс эхлэн дагаж мөрдөнө.
19.3.энэ хуулийн 6.1.4-т заасан төсвийн тусгай шаардлагыг хөгжлийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрийн бодит хэрэглээ, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашиглалтаас төсөвт оруулах орлого, тэдгээр орд ашиглалтын урьдчилгаа төлбөрийн боломж, өмнөх жилүүдэд авч ашигласан гадаад зээлийн эргэн төлөлтийн хуваарьтай уялдуулж, үе шаттай хэрэгжүүлэх зорилгоор улсын нийт өрийн өнөөгийн цэвэр үнэ цэнээр илэрхийлсэн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг 2011 оны төсвийн жилд 50 хувиас, 2013 оны төсвийн жилд 60 хувиас, 2013 оны төсвийн жилд 50 хувиас, 2014 оны төсвийн жилээс эхлэн 40 хувиас тус тус хэтрүүлэхгүй байна.	"19.3.Энэ хуулийн 6.1.4-т заасан төсвийн тусгай шаардлагыг үе шаттайгаар хэрэгжүүлэх зорилгоор өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн улсын нийт өрийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг 2015 оны төсвийн жилд одоо байгаа түвшинд нь буюу 58.3 хувиас, 2016 оны төсвийн жилд 55 хувиас, 2017 оны төсвийн жилд 50 хувиас, 2018 оны төсвийн жилээс эхлэн 40 хувиас тус тус хэтрүүлэхгүй байна."			19.3.Энэ хуулийн 6.1.4-т заасан төсвийн тусгай шаардлагыг үе шаттайгаар хэрэгжүүлэх зорилгоор өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн өрийн үлдэгдлийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг 2015 оны төсвийн жилд 58.3 хувиас, 2016 оны төсвийн жилд 88 хувиас, 2017 оны төсвийн жилд 85 хувиас, 2018 оны төсвийн жилд 80 хувиас, 2019 оны төсвийн жилд 75 хувиас, 2020 оны төсвийн жилд 70 хувиас, 2021 оны төсвийн жилээс эхлэн 60 хувиас тус тус хэтрүүлэхгүй байна."
19.4.Энэ хуулийн 19.3-т заасны дагуу өнөөгийн цэвэр үнэ цэнээр илэрхийлсэн улсын нийт өрийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээний 40 хувиас давсан хэсэгт Засгийн газар зөвхөн энэ хуулийн 17.1-д заасан санхүүгийн хуримтлал бий болгох хүртэлх хугацаанд энэ хуулийн 17.4.1, 17.4.2-т заасан хөгжлийн хөрөнгө оруулалтын зориулалтаар төрийн өмчит хөгжлийн банканд зээлийн баталгаа гаргана.				
19.5.Энэ хуулийн 16.2-т заасан нөхцөлийг 2018 оны төсвийн жилээс өмнө хангана				"19.5.Энэ хуулийн 16.2-т заасан нөхцөлийг 2020 оны төсвийн жилээс өмнө хангана.
	"19.6.Энэ хуулийн 6.1.2-т заасан нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлыг 2015 онд тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний 5 хувиас, 2016 онд тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний 4 хувиас, 2017 онд тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний 3 хувиас, 2018 оны төсвийн жилээс эхлэн тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний 2 хувиас тус тус хэтрүүлэхгүй байна."			19.6.Энэ хуулийн 6.1.2-т заасан нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлын тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг 2015 онд 5 хувиас, 2016 онд 18.5 хувиас, 2017 онд 9.9 хувиас, 2018 онд 7.5 хувиас, 2019 онд 5.5 хувиас тус тус хэтрүүлэхгүй, 2020 оны төсвийн жилээс эхлэн нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг алдагдалгүй байлгана."
Хууль өөрчлөх босго	19.7 хүчингүй			
		"19.8.Энэ хуулийн 19.6-д заасны дагуу нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлыг тооцоход энэ хуулийн 6.2-т заасан салбарын хуулийн этгээдэд Засгийн газрын гадаад зээллэгийн эх үүсвэрийг дамжуулан зээлдүүлэх замаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санхүүжилтийг оруулж тооцохгүй."		
2017-04-14	2021-07-07	2023-07-07	2024-06-05	2024-08-30
		6.4.Энэ хуулийн 6.1.2-т заасан тусгай шаардлагыг 2025 оны төсвийн жил хүртэл, 6.1.4-т заасан тусгай шаардлагыг 2024 оны	6.4.Энэ хуулийн 6.1.2-т заасан тусгай шаардлагыг 2025 оны төсвийн жил хүртэл, 6.1.4-т заасан тусгай шаардлагыг 2025 оны төсвийн жилээс хэрэгжүүлнэ.	"6.1.2.нэгдсэн төсвийн суурь тэнцэл нь тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр буюу түүнээс дээш хувийн ашигтай байх;

		төсвийн жил хүртэл үе шаттай хэрэгжүүлж болно.		"6.6.Энэ хуулийн 6.1.2-т заасан суурь тэнцлийн ашгийг Засгийн газрын өрийн үндсэн төлбөрийг төлж барагдуулахад зарцуулна." 6.4 дэх хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.
				6.1.3.нэгдсэн төсвийн урсгал зарлагын хэмжээ тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний 30 хувиас хэтрэхгүй байх;"
		6.5.Энэ хуулийн 6.1.2, 6.1.4-т заасан тусгай шаардлагын доод хэмжээг бууруулахыг, энэ хуулийн 6.4-т заасан хугацааг сунгахыг хориглоно."	6.5.Энэ хуулийн 6.1.2-т заасан тусгай шаардлагын доод хэмжээг бууруулах, 6.1.4-т заасан тусгай шаардлагын дээд хэмжээг нэмэгдүүлэх, 6.4-т заасан хугацааг сунгахыг хориглоно."	6.1.4 дэх заалтын "өнөөгийн үнэ цэнээр" гэснийг "нэрлэсэн дүнгээр" , мөн зүйлийн 6.5 дахь хэсгийн "нэмэгдүүлэх, 6.4-т заасан хугацааг сунгахыг" гэснийг "нэмэгдүүлэхийг" гэж
19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийн "2020" гэснийг "2023" гэж,	19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийн "2023" гэснийг "2025" гэж өөрчилсөн.			19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийн "2025" гэснийг "2024" гэж,
	19.2 дахь хэсгийн "2021" гэснийг "2024" гэж өөрчлөв.			
	19.3 дахь хэсгийн "2021 оны төсвийн жилээс эхлэн 60 хувиас тус тус хэтрүүлэхгүй байна." гэснийг "2021 болон 2022 оны төсвийн жилд 70 хувиас, 2023 оны төсвийн жилд 65 хувиас, 2024 оны төсвийн жилээс эхлэн 60 хувиас тус тус хэтрүүлэхгүй байна." гэж тус тус өөрчилсүгэй.			19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсгийн ", 2024 оны төсвийн жилээс эхлэн 60 хувиас" гэснийг хассугай.
19 дүгээр зүйлийн 19.5 дахь хэсгийг хүчингүй болгов				
19.6 дахь хэсгийн ", 2017 онд 9.9 хувиас, 2018 онд 7.5 хувиас, 2019 онд 5.5 хувиас тус тус хэтрүүлэхгүй, 2020 оны төсвийн жилээс эхлэн нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг алдагдалгүй" гэснийг "хэтрүүлэхгүй" гэж тус тус өөрчилсүгэй.				
"19.9.Энэ хуулийн 6.1.2-т заасан нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлын тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг 2017 онд 10.4 хувиас, 2018 онд 9.5 хувиас, 2019 онд 6.9 хувиас, 2020 онд 5.1 хувиас, 2021 онд 3.6 хувиас, 2022 онд 2.8 хувиас тус тус хэтрүүлэхгүй, 2023 оны төсвийн жилээс эхлэн нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байна."	19.9.Энэ хуулийн 6.1.2-т заасан нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлын тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг 2017 онд 10.4 хувиас, 2018 онд 9.5 хувиас, 2019 онд 6.9 хувиас, 2020 онд 12.5 хувиас, 2021 онд 8.8 хувиас, 2022 онд 5.1 хувиас, 2023 онд 3.6 хувиас, 2024 онд 2.8 хувиас тус тус хэтрүүлэхгүй, 2025 оны төсвийн жилээс эхлэн нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байна."			19.9 дэх хэсгийн "Энэ хуулийн 6.1.2-т" гэснийг "Энэ хуульд" гэж тус тус өөрчилсүгэй.

Төсвийн тусгай шаардлагын хувьд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3 дахь заалтад "тухайн жилийн нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь нь тухайн жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн хувь, тухайн жилийн өмнөх дараалсан 12 жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн дунджийн аль ихээс хэтрэхгүй байх;" гэсэн шаардлагаас бусад шаардлага нь өнөөдрийг хүртэл бүрэн хэрэгжээгүй байна. Харин мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3 дахь заалтад заасан

тусгай шаардлагыг 2017 оноос хэрэгжүүлж ирсэн ч 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар уг шаардлагыг дараах агуулгаар өөрчлөн найруулсан байна. Үүнд:

“6.1.3.нэгдсэн төсвийн урсгал зарлагын хэмжээ тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний 30 хувиас хэтрэхгүй байх;”

Гэвч, дээрх өөрчлөлт нь агуулгын хувьд Монгол Улсын Үндсэн хуультай бүрэн нийцэхгүй байна гэж дүгнэж байна. Тодруулбал, Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн. Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ. Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.” гэж заасан.

Үндсэн хуулийн агуулгаар газрын хэвлийн баялгийн үр өгөөж нь одоо ба ирээдүй үеийн иргэдэд тэгш, шударга хүртээх зорилгоор Үндэсний баялгийн сангаар дамжуулан хуваарилж байхаар хуульчилсан. Иймээс ч байгалийн шавхагдах нөөц баялгаас нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийг тооцож, түүнийг өнөө болон ирээдүйн иргэдэд хэрхэн үр ашигтай хуваарилах асуудал нь төсвийн бодлогын нэг чухал үзүүлэлт болно. Энэ агуулгаар төсвийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн тусгай шаардлагыг тодорхойлохдоо байгалийн шавхагдах нөөцийг нэг дор бүрэн дайчлахгүй байх бодлогыг баримтлах нь Үндсэн хуулийн суурь зарчим билээ. Гэвч, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдөр орсон нэмэлт, өөрчлөлтөөр дээрх Үндсэн хуульд тодорхойлсон суурь зарчмыг зөрчих өөрчлөлт орсон байна.

Тодруулбал, нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувийг эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн хувьтай дүйцүүлэн тооцож байсан төсвийн тусгай шаардлагыг дээрх хуулийн өөрчлөлтөөр өөрчлөн, эрдэс баялгийн бүтээгдэхүүний өсөлтийг тухайн жилийн зарлагад тооцдог байхаар тусгасан нь байгалийн баялгийн үр өгөөжийг өнөө болон ирээдүй үед тэгш шударга хүртээх боломжийг хаасан байна.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг батлахаас өмнөх үеийн нийгэм, эдийн засгийн байдлын талаар Монголбанкнаас гаргасан судалгаанд дараах байдлаар дурдсан байдаг. Үүнд:

Шавхагддаг байгалийн баялаг тухайлбал, газрын тос, нүүрс, зэс зэрэг нь ашигласны хэрээр буурч байдаг нөөц юм. Шавхагддаг байгалийн баялгийг тогтвортой удаан хугацаанд ашиглах боломжгүй боловч түүнээс олсон орлогыг эдийн засаг урт хугацаанд тогтвортой хөгжихөд ашиглаж болно. Байгалийн шавхагддаг баялгаас олсон орлогыг өөр хэлбэрийн баялаг руу тухайлбал биет капитал, хүний нөөц рүү хөрөнгө оруулалт хийх замаар шилжүүлэх нь тогтвортой хөгжлийн гол суурь байх юм.

Улс үндэстнүүдийн баялаг нь хүний гараар бүтээгдсэн бодит баялаг, хүмүүн капитал, нийгмийн баялаг болон байгалийн баялаг зэргээс бүрдэнэ. Тухайн жилийн

байгалийн баялаг нь өмнөх үеийн байгалийн баялаг, тухайн жилийн ашиглалтаас хамаарах юм. Өөрөөр хэлбэл байгалийн баялгаа ашиглахын хэрээр улс орны ирээдүйн нийт баялаг буурч байдаг гэсэн үг юм.


ОУВС 1995 оноос эхлэн улс орнуудын баялгийг үнэлэх зорилгоор дээрх үзүүлэлтүүдийг цуглуулан нэгтгэн гаргах болсон. Хүснэгт 1-д үзүүлсэнээр 2005 оны байдлаар Монгол Улсын нэг хүнд ногдох баялаг дэлхийн нэг хүнд ногдох баялгаас бараг 10 дахин бага байгаа бол нөхөн сэргээгддэггүй байгалийн баялаг ч мөн 2 дахин бага байна.

Хүснэгт 1. Нэг хүнд ногдох баялаг

	2000 онд Монгол (нэг хүнд ногдох)	2005 онд Монгол (нэг хүнд ногдох)	2005 онд Дэлхий (нэг хүнд ногдох)
Биет бус капитал	1,449	4,229	92,770
Хүний гараар бүтээгдсэн капитал	3,947	3,675	21,137
Нөхөн сэргээгдэх байгалийн баялаг	7,265	4,291	4,266
Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	795	1,186	2,301
Нийт баялаг	13,456	13,381	120,475

Хүснэгтээс харахад 2000 онд Монголын нэг хүнд ногдох баялаг 13,456 ам.доллар байсан бол 2005 онд буурч 13,381 болсон нь голчилж нөхөн сэргээгдэх баялгийн бууралтаас болсон байна. 2000-2005 оны хугацаанд байгалийн баялаг нь буурсан орнуудын бусад баялаг хэдий хэмжээгээр нэмэгдсэнийг Зураг 1-ээс харж болно. Өөрөөр хэлбэл улс орнууд байгалийн баялгаа хэрхэн үр ашигтай зарцуулж вэ? гэдгийг харна гэсэн үг юм.

Зураг 1. Байгалийн баялгийн бууралт, бусад баялгийн өсөлт



Зургаас харахад 2000-2005 онд Монгол Улс байгалийн баялгаа 32%-аар бууруулсан боловч түүнээс олсон орлогоороо бусад баялгийг тэр хэмжээгээр бий болгож чадаагүй /түүний өгөөж нь 1-ээс бага байна/ тул нэг хүнд ноогдох баялаг буурсан байна. Байгалийн баялаг нь буурсан бусад орнуудын хувьд өгөөж нь 1-ээс их байгаагаас үзэхэд Монгол улс баялгаас олсон орлогоо бусад баялгийг бий болгоход зарцуулаагүй нь харагдаж байна.

Шавхагддаг баялгаа зарцуулахдаа бусад баялгийг бий болгоход зориулж чадахгүй байгааг төсвийн зардлын бүтцээс мөн харж болно. Зураг 2-т төсвийн орлого, зардлын бүтцийг ДНБ-д эзлэх хувиар үзүүлэв.

Зураг 2. Төсвийн орлого, зардлын бүтэц, ДНБ-д эзлэх хувиар



2006-2008 онуудад эрдэс бүтээгдэхүүний үнийн өндөр өсөлт, түүхий эдийн үнийн гэнэтийн өсөлтийн татвар зэргээс шалтгаалан төсвийн эрдэс бүтээгдэхүүний орлого их байсан бөгөөд орлогын өсөлтийг дагаад төсвийн зардал ч мөн өсч байсан.

Төсвийн зардлыг бүтцээр нь авч үзвэл 1999-2005 онуудад төсвийн цалин, шилжүүлгийн зардал 13.5%, бусад зардал, хөрөнгө оруулалтын зардлыг оруулаад 21.7%-ийг эзэлж байсан бол 2006-2009 онуудад цалин, шилжүүлгийн зардал 17.6% болж өсч, бусад зардал 18.8% болж буурчээ. Үүнээс харахад баялаг зарж олсон орлого нь баялаг бүтээхэд биш хэрэглээг урамшуулахад түлхүү зарцуулагдаж байна гэсэн үг юм.

Саудын Арабын Хаан Файсал (1964-1975): “Нэг үе маань тэмээ унахаа болиод кадилак унадаг боллоо. Мөнгөө хэрхэн зарцуулж байгааг харахад дараагийн үе маань буцаад тэмээ унадаг болох вий гэж санаа зовоож байна” гэсэн нь баялгаас олсон орлогоороо бусад баялгийг бүтээхгүй бол тогтвортой өсөлтийг бий болгож чадахгүйг далд утгаар хэлжээ.

Дээрх нөхцөл байдлын улмаас Монгол Улс баялгийн хараалаас урьдчилан сэргийлж, төсвийн шинэчлэл хийж, төсвийг тусгай шаардлагыг хуульчилсан байдаг ч 2024 оны 08 дугаар сарын 30-ны өөрчлөлтөөр дээрх шинэчлэлээс ухрах шийдлийг бий болгосон байна.

БАЙГАЛИЙН БАЯЛАГТАЙ ОРНУУДАД ТУЛГАРДАГ БЭРХШЭЭЛ

Байгалийн баялгийн хоёр онцлог шинж байдаг. Нэгдүгээрт, байгалийн баялаг нь хүний гараар бүтээгддэггүй учраас эдийн засгийн бусад салбаруудаас хамаарахгүйгээр, дотоодын их хэмжээний ажиллах хүчийг ашиглахгүйгээр газраас ухаад гаргаж болдог оронцлог юм. Хоёрдугаарт, ихэнх байгалийн баялаг нь нөхөн сэргээгддэггүй баялаг байдаг. Тухайлбал, газрын тос, эрдэс, металл гэх мэт.

Иймд нөхөн сэргээгддэггүй байгалийн баялаг нь орлого гэхээсээ илүү хөрөнгө гэсэн ангилалд орно. Дээрх хоёр шинж чанараас болоод дотоодын эдийн засагт төдийгүй улс төр, нийгэмд олон сөрөг үр дагаврыг авчирдаг. Байгалийн баялаг ихтэй орнуудад тулгардаг нийтлэг бэрхшээлийг тоймлон дурдвал:

- Голланд өвчин (Бодит валютын ханшны чангаралт нь байгалийн баялгийн бус экспорт болон импортыг орлох аж үйлдвэрлэлийг шахаж, өрсөлдөх чадваргүй болгон хумьдаг.)
- Хэт их хэлбэлзэл (Түүхий эдийн үнэ нь бусад бараа бүтээгдэхүүнтэй харьцуулахад хэлбэлзэл өндөртэй байдгаас түүнийг экспортлогч орнууд макро эдийн засгийн хэлбэлзэлд өртөмтгий байдаг. Түүнчлэн, байгалийн нөөц баялгийн экспортыг дагасан төсвийн зохисгүй бодлого болон санхүүгийн урсгал нь макро эдийн засгийн хэлбэлзлийг улам дэврээ дэг. Хэт их хэлбэлзэл нь хөрөнгө оруулалт улмаар, эдийн засгийн тогтвортой өсөлтөд сөргөөр нөлөөлөх болно.)
- Макро эдийн засгийн мөчлөг дагасан байдал (Түүхий эдийн өндөр үнийг дагасан төсвийн орлогын өсөлт нь засгийн газрын зардлаа нэмэгдүүлэх үйлдлийг өдөөж, төсвийн зардлыг хянахад улам хэцүү болгодог.)
- Эдийн засгийн төрөлжилтийг бууруулалт (Байгалийн нөөц баялгийг олборлон экспортлох нь эдийн засгийн төрөлжилтөд сөрөг нөлөөтэй. Энэ нь эргээд хэдхэн төрлийн бүтээгдэхүүний үнээс эдийн засгийг хэт хараат болоход нөлөөлдөг.)
- Ашиг хонжоо хайх байдал (Ашиг хонжоо гэдгийг баялгийг газраас ухаж гаргах зардал, түүний өнөөгийн үнэ цэнэ хоёрын зөрүү гэж ойлгож болох бөгөөд дээр дурдсан бэрхшээлүүдээс хамгийн хор хөнөөлтэй нь “Ашиг хонжоо хайх явдал” гэж үзэж болох юм.)

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

Нэгэнт дээр дурдсан бэрхшээлүүд байгалийн баялаг ихтэй орнуудад нийтлэг тулгардаг бол эдгээр бэрхшээлийг даван туулах нийтлэг хандлага ч мөн байх ёстой. Баялгийн орлогыг авах, захиран зарцуулах эрх ихэвчлэн тухайн орны засгийн газрын мэдэлд байдаг тул байгалийн баялгаар тогтвортой өсөлтийг бий болгож чадах эсэх нь төсвийн бодлогоос ихээхэн хамаарна. Мөнгөний болон ханшийн бодлого ч мөн нөлөөтэй юм. Гэхдээ мэдээж байгалийн баялаг экспортлогч улсуудын эдийн засгийн суурь хүчин зүйлс харилцан адилгүй байдаг тул макро эдийн засгийн бодлого, түүний нөлөө ч мөн харилцан адилгүй байх нь ойлгомжтой юм.

Төсвийн бодлого

Төсвийн бодлого орлогоо үр ашигтай цуглуулдаг (хэзээ хэр хэмжээгээр олборлолт хийх нь зохистой вэ гэдгээ шийддэг), төсвийн зардал нь хэрэглээг урамшуулахаас илүүгээр тогтвортой өсөлтийг дэмжсэн байх шаардлагатай бөгөөд өнөө үеийн хүн ард төдийгүй тэдний үр ач нарыг хангалуун амьдруулах бодлогын тэр зөв хувилбарыг сонгох нь чухал юм. Түүнчлэн, төсвийн бодлого нь түүхий эдийн экспортын орлогоос үүдэлтэй шокын нөлөөг саармагжуулж мөчлөг сөрсөн байх шаардлагатай. Төсвийн зохистой бодлогыг амжилттай хэрэгжүүлж буй улсууд байгалийн баялгийн санг байгуулж, төсвийн мөчлөг сөрсөн бодлогыг тогтвортой байдлын хуулиар зохицуулж байна.

Мөнгөний бодлого

Мөнгөний болон ханшийн бодлого нь инфляцыг нам тогтвортой түвшинд байлгах, түүхий эдийн үнийн хэлбэлзлээс үүдэлтэй эдийн засгийн мөчлөгийн хэт савалгааг багасгахад чиглэгдсэн байх шаардлагатай юм. Түүнчлэн, валютын их хэмжээний орох урсгалаас үүдэлтэй эдийн засгийн хэт халалт, үл хөдлөх хөрөнгийн үнийн хөөсрөлт, санхүүгийн захын тогтворгүй байдал зэрэг нь төв банкны хувьд хүндхэн сорилт болж мөчлөг сөрсөн зохистой бодлого явуулахыг шаарддаг. Байгалийн баялгийн экспорт, түүнийг дагасан төсвийн тэлэх бодлого бодит ханшны чангаралтыг улам дэврээдэг гэж өмнө дурдсан билээ. Бодит ханшийн чангаралтын үед мөнгөний бодлогоор 1) инфляцыг хянаад нэрлэсэн ханшийн чангаралтыг зөвшөөрөх, 2) ханшаа тогтмол барихын тулд интервенци хийж инфляцыг өсгөх, 3) ханшаа тогтмол барьж интервенцдээ бүрэн стерилизаци хийснээр хувийн хөрөнгө оруулалтыг шахах гэсэн бодлогын хувилбаруудаас сонголт хийхээс өөр аргагүйд хүрдэг. Монголбанкны хувьд 2010 онд орж ирсэн валютын урсгалын ойролцоогоор 40%-д интервенц хийж, хийсэн интервенцийнхээ 50 орчим хувьд, нийт орсон урсгалын 20 хувьд стерилизаци хийсэн байна. 14 Энэхүү стерилизацийн зардал буюу ТБҮЦ-ны хүүний зардал 2010 оны ДНБ-ий 0.8%-тай тэнцэж байна. Дараагийн бүлэгт төсвийн болон мөнгөний бодлогын эдийн засагт үзүүлэх нөлөөг ДСЕТ-ийн загварт симуляци хийх замаар харуулах болно.

ДҮГНЭЛТ

Энэхүү судалгааны хүрээнд авч үзсэн асуудлуудыг базаж нэгтгэн дараах дүгнэлтийг хийж болно. Нэгдүгээрт, байгалийн баялагтай орнуудад тулгардаг нийтлэг бэрхшээлүүд Монгол улсын эдийн засагт хэдийнээ тулгарсан байна. Хоёрдугаарт, одоогийн төсөв, мөнгөний бодлогын хослол нь дунд, урт хугацаанд эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангаж чадахааргүй байна. Төсвийн бодлогын хувьд уул уурхайн орлогоос хуримтлал үүсгэлгүйгээр бүгдийг зарцуулах нь, зарцуулахдаа хөрөнгө оруулалтад бус хэрэглээг санхүүжүүлж байгаа нь богино

хугацаанд инфляцыг хөөрөгдөж, урт хугацаанд эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлөхөөр байна.

Засгийн газар уул уурхайн орлогын дорвитой хэсгийг хуримтлуулж хадгалах, орлогыг зарцуулахдаа ихэвчлэн хөрөнгө оруулалтад хийх, төв банк интервенц хийхээс аль болох зайлсхийх нь нам, тогтвортой инфляц бүхий дунд болон урт хугацааны эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжсэн, бодлогын үр ашигтай сонголт болохоор байна. Шавхагддаг нөөц баялгаа зарж борлуулсан орлогоо бусад баялаг болох хүний гараар бүтээгдсэн бодит баялаг, хүмүүн капитал, нийгмийн баялгийг бий болгоход зарцуулах шаардлагатай байна.

Иймд дээрх үндэслэлээр Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах хэрэгцээ шаардлага үүссэн.

Энэхүү хуулийн төсөл батлагдсанаар Үндсэн хуульд заасан байгалийн баялгийн үр өгөөжийг өнөө ба ирээдүйн үед тэгш, шударга хүртээх эрх зүйн орчин бүрдэж, улмаар төсвийн тогтвортой байдлыг хангах замаар макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангаж, улс орны нийгэм, эдийн засагт эерэг нөлөөлөл үзүүлэхээр байна.

ХОЁР. Асуудлыг шийдвэрлэх зорилго

2.1. Гол зорилго, зорилт

Энэхүү үнэлгээний тайлангийн нэгд заасан асуудлыг шийдвэрлэх хэрэгцээ шаардлага урган гарч байгаатай холбогдуулан Аргачлалын 4-т заасны дагуу асуудлыг шийдвэрлэх ерөнхий зорилгыг дараах байдлаар тодорхойлж байна.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар төсвийн тусгай шаардлагыг Үндсэн хуульд нийцүүлж, Монгол Улсын нийгэм, эдийн засагт эерэг нөлөөлөл үзүүлэх буюу төсвийн тогтвортой байдлыг хангах, төсвийн хариуцлагатай байх зарчмуудыг бодитоор хэрэгжүүлэх боломж бүрдэнэ.

ГУРАВ. Асуудлыг зохицуулах хувилбарууд, тэдгээрийн харьцуулалт

3.1. Асуудлыг зохицуулах хувилбарууд

Энэхүү үнэлгээний тайлангийн Нэгд заасан асуудлыг шийдвэрлэх боломжтой хувилбаруудыг тогтоож, Аргачлалын 5-д заасны дагуу “зорилгод хүрэх байдал” буюу Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах замаар нийгэм дээрх бэрхшээлийг арилгах зорилгоор шийдлийг сонгох хувилбарыг Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.3 дахь заалт, Хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалд тус тус заасны дагуу Хуулийн төсөл боловсруулах шаардлагатай гэж үзэж байна.

Асуудалд дүн шинжилгээ хийх явцад хуулийг батлахгүйгээр асуудлыг шийдвэрлэх гарцуудын талаар тодорхой судалгаанууд хийгдсэн.

- “Тэг” хувилбар буюу хуулийн төсөл боловсруулахаас татгалзах. Энэ тохиолдолд өнөөгийн мөрдөж буй эрх зүйн зохицуулалтын хүрээнд зохицуулалт байх боловч одоо үүсч буй хэрэгцээ шаардлагыг хангах боломжгүй байна. Төсвийн тусгай шаардлага нь төсвийн бодлогын баримт бичгийг боловсруулах суурь нөхцөл

байх тул уг асуудлаар хуульд тодорхой өөрчлөлт оруулахгүйгээр, төсвийн тусгай шаардлагыг нөхцөлийг хангуулах боломжгүй.

- Хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх. Уг асуудал нь хуулиар шууд зохицуулагдах харилцаа учир хуулийн төсөл боловсруулах шаардлагатай.
- Зах зээлийн механизмаар төрөөс зохицуулалт хийх. Төрөөс санхүүгийн интервенц хийх. Төрөөс санхүүгийн интервенц хийх буюу шууд мөнгөн хэлбэрийн дэмжлэг үзүүлэх аргаар зохицуулах боломжгүй юм. Энэ нь төсвийн тогтвортой байдлыг хангах зорилгын хүрээнд төсвийг боловсруулах суурь шаардлага байх тул энэ аргаар асуудлыг шийдвэрлэх боломжгүй.
- Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх. Төсвийн тусгай шаардлага нь төсөв боловсруулахад баримтлах суурь шаардлага бөгөөд үүнийг аль нэг байгууллагаа гүйцэтгээд үр дүн байхгүй.
- Захиргааны шийдвэр гаргах. Төсвийн тусгай шаардлагыг хуулиар тогтоодог тул захиргааны шийдвэрээр асуудлыг шийдвэрлэх боломжгүй юм.
- Хууль тогтоомжийн төсөл боловсруулах. Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасны дагуу хуулийн төсөл батлах замаар шийдвэрлэх боломжтой юм.

3.2. Зохицуулалтын хувилбаруудын эерэг болон сөрөг талыг харьцуулсан тухай

Зорилгод хүрэх байдал: Зорилгод хүрэх байдлыг өмнө хийгдсэн судалгаа, санал асуулга, ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээдүүд болон салбарын мэргэжилтнүүдийн санал зэргийг үндэслэн тодорхойллоо.

Тэг хувилбарыг сонгосноор тухайн асуудал шийдвэрлэгдэхгүй орхигдох сөрөг талтай.

Хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх хувилбарыг сонгосноор тухайн харилцааг зохицуулах боломжгүй тул уг хувилбарыг сонгох боломжгүй байна.

Зах зээлийн механизмаар төрөөс зохицуулалт хийх. Төрөөс санхүүгийн интервенц хийх хувилбарыг сонгосноор төрөөс санхүүгийн интервенц хийх буюу шууд мөнгөн хэлбэрийн дэмжлэг үзүүлэх аргаар зохицуулах боломжгүй юм.

Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх хувилбарыг сонгох боломжгүй бөгөөд хуульд заасны дагуу төрийн байгууллага өөрөө хариуцан гүйцэтгэх шаардлагатай.

Захиргааны шийдвэр гаргах хувилбар сонгосноор бүрэн хэрэгжилтийг хангах боломжгүй юм.

Зардал, үр өгөөжийн харьцаа: Хуулийн төсөл баталснаар нэмэлт зардал гарахгүй тул зардлын тооцоо хийх шаардлагагүй. Энэхүү төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн чиг үүрэг, санхүүжилт нь төсвийн хуульд туссан байгаа.

3.3. Хамгийн үр дүнтэй хувилбарын тухай

Энэхүү тандан судалгааг хийх явцад зохицуулалтын нэг л хувилбар буюу хууль тогтоомжийн төслийг боловсруулах хувилбарыг сонгон авсан болно. Хууль тогтоомжийн тухай хуулийн 5.1-т заасны дагуу хуулийн төсөл боловсруулан хуулийн төсөл батлах замаар шийдвэрлэх боломжтой гэж үзсэн.

ДӨРӨВ. Зохицуулалтын хувилбарын үр нөлөөний талаар

Аргачлалын 5.5-т заасны дагуу хуулийн төсөл боловсруулах нэг хувилбарыг сонгосон ба үүнтэй холбогдуулан сонгосон нэг хувилбарын үр нөлөөг Аргачлалын 6-д заасны дагуу ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлтийг нэгтгэн гаргалаа.

4.1. Хүний эрх, нийгэм, эдийн засаг, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

4.1.1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн. Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ. Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно. гэж заасан. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Алсын хараа 2050” Монгол Улсын Урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-ны “Зорилт 4.1.2. Төсвийн хөрөнгийг эдийн засаг, нийгмийн хөгжилд чиглүүлсэн, үр ашигтай, хариуцлагатай төсөв, санхүүгийн тогтолцоотой болсон байна.” гэж тус тус заасны дагуу уялдуулан боловсруулна.

Хуулийн төсөл боловсруулах хувилбар нь хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж байгаа нь Аргачлалын 6.2-т заасан хүний эрхэд үзүүлэх үр нөлөөний суурь асуултын хариулт /Хавсралт хүснэгт 1/-аас харагдаж байна.

4.1.2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Улсын төсөвт төсвийн тогтвортой, хариуцлагатай байх зарчмыг хангуулах замаар эдийн засагт эерэг нөлөөлөл үзүүлнэ. Энэ нь Аргачлалын 6.2-т заасан эдийн засагт үзүүлэх үр нөлөөний суурь асуултын хариулт /Хавсралт хүснэгт 2/-оос харагдаж байна.

4.1.3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Хуулийн төсөл боловсруулах хувилбарын хувьд Аргачлалын 6.2-т заасан нийгэмд үзүүлэх үр нөлөөний суурь асуултын хариулт /Хавсралт хүснэгт 3/-аас харахад нийгэмд эергээр нөлөөлөхөөр байна.

4.1.4. Байгаль орчинд үзүүлэх нөлөө

Аргачлалын 6.2-т заасан байгаль орчинд үзүүлэх үр нөлөөний суурь асуултын хариулт /Хавсралт-4/-аас харахад хуулийн төсөл боловсруулах хувилбар нь байгаль орчинд ямар нэгэн шууд болон шууд бус сөрөг нөлөө үзүүлэхгүй байна.

4.2. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэх талаар

Монгол Улсын Үндсэн хуулийн зарчим, зохицуулалтын хүрээнд нийцүүлэн хуулийн өөрчлөлтийн төсөл боловсруулагдсан болно. Монгол Улсын нэгдэн орсон олон улсын нийт гэрээтэй тогтоолын төслийн агуулга нь зөрчилдсөн зүйл байхгүй болно.

ТАВ. ЗӨВЛӨМЖ

Аргачлалын 9-д заасны дагуу энэхүү үнэлгээний тайлангийн 5 дахь хэсгийн “Зохицуулалтын хувилбаруудыг харьцуулсан дүгнэлт”, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн нийгмийн хэрэгцээ, шаардлага болон Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуульд нийцүүлж, нийгмийн харилцаанд үүсэж байгаа нөхцөл байдлыг сайжруулах зорилгын хүрээнд дараах зөвлөмжийг боловсрууллаа.

- Улс орны эрх ашигт нийцэж байх тул нэн яаралтай хууль боловсруулах хэрэгцээ шаардлагатай
- Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу уялдуулан боловсруулах.

**ХҮНИЙ ЭРХ, ЭДИЙН ЗАСАГ, НИЙГЭМ, БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ
ҮР НӨЛӨӨНИЙ ТАНДАЛТЫН СУДАЛГАА ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ**

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар
1.Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж байгаа эсэх	1.1.Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх		
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.1.3.Тодорхой эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ бол олон улсын болон үндэсний хууль тогтоомжид заасан хүний эрхийн хэм хэмжээтэй нийцэж байгаа эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.2.Оролцоог хангах		
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.2.2.Зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.3.Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал, хариуцлага		
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхүүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, хүний эрхийг хамгаалах механизмийн талаар НҮБ-аас өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм	Монгол Улсын нэгдэн орсон Олон улсын гэрээнд аливаа байдлаар харшлаагүй бөгөөд хүний эрхийг хамгаалахад чиглэгдэж байна.

	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2.Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1.Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах тохиолдолд энэ нь хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2.Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	Үгүй	Ямар нэгэн хязгаарлалт тогтоохгүй
3.Эрх агуулагч	3.1.Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.2.Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	Үгүй	Ямар нэгэн байдлаар ялгаж тодорхойлоогүй
	3.3.Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.4.Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх (хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй)	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Үүрэг хүлээгч	4.1.Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм	Төр үүрэг хүлээнэ
5.Жендэрийнэрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1.Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Үгүй	Уг тогтоолд жендэрийн эрх хөндөгдөхгүй болно.
	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Үгүй	Уг тогтоолд жендэрийн эрх хөндөгдөхгүй болно.

ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг Монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний үрэлмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Инноваци болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх		
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Эерэг нөлөө үзүүлнэ.
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	10.3.Инфляц нэмэгдэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм	Олон улсын гэрээ, хэлэлцээртэй нийцнэ.

НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	Үгүй	Шинээр ажлын байр бий болохгүй
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхтгол бий болгох эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуучимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар
1.Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Усны нөөц	4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
5.Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Газрын ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7.Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхийг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

---oO---

ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ

НЭГ.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /цаашид “хуулийн төсөл” гэх/-ийн төслийн үр нөлөөг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр хуулийн 3 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-д /цаашид “аргачлал” гэх/ заасны дагуу үнэлсэн болно.

Хуулийн төслийг аргачлалд заасны дагуу дараах үе шаттай хийлээ:

- Ерөнхий зүйл
- Шалгуур үзүүлэлтийг сонгох
- Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох
- Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

ХОЁР.ХУУЛИЙН ТӨСЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан, аргачлалд дурдсан 6 шалгуур үзүүлэлтээс 3 шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

- Зорилгод хүрэх байдал
- Ойлгомжтой байдал
- Харилцан уялдаа зэрэг болно.

“**Зорилгод хүрэх байдал**” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зорилго нь үзэл баримтлалд тусгасан хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцэж буй байдал, хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалтууд нь хуулийн төслийн зорилгод хүрэх боломжтой эсэхийг үнэллээ.

Энэхүү үнэлгээг хийхдээ хуулийн төслийн үзэл баримтлалтай танилцаж, хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага, хуулийн төслийн зорилго болон зорилгод хүрэхэд чиглэгдсэн, мөн түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц арга хэмжээ, зохицуулалтыг сонгож авсан болно.

“**Ойлгомжтой байдал**” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл нь боловсруулалтын хувьд Хууль тогтоомжийн тухай хуулийн 29, 30 дугаар зүйл болон Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг, түүнчлэн хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдүүд хуулийг ойлгож хэрэглэх, хэрэгжүүлэх боломжтой байдлаар боловсруулагдсан эсэхийг шалгахын тулд хуулийн төслийг бүхэлд нь сонгон авлаа.

“**Харилцан уялдаа**” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг бүхэлд нь Үндсэн хууль холбогдох бусад хуульд нийцсэн эсэхийг аргачлалд заасан асуултад хариулах байдлаар үнэлгээг хийхээр тооцов.

ГУРАВ.УРЬДЧИЛАН СОНГОСОН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу үр нөлөөг үнэлэхэд хамруулах хэсэг, түүнийг шалгах хэрэгслийг хүснэгтийн дагуу тогтоолоо. Үүнд:

Д/д	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Шалгах хэрэгсэл
1.	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төсөл бүхэлд нь	Хуулийн төслийн үзэл баримтлалд дэвшүүлсэн зорилтыг хангах эсэхэд дүн шинжилгээ хийх
2	Ойлгомжтой байдал	Хуулийн төслийн зохицуулалтыг бүрэлд нь	Хууль тогтоомжийн тухай хуулийн 29, 30 дугаар зүйл, хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах
3.	Харилцан уялдаа	Хуулийн төсөл бүхэлд нь	Хуулийн төслийн уялдаа холбоог Хууль тогтоомжийн тухай хууль болон аргачлалд заасан асуулгуудаар шалгах

Дээрх урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирсон шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг дараах байдлаар үнэллээ.

3.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлагад хуулийн төслийн зорилт, зохицуулалтууд нь нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх үүднээс хуулийн төслийн үзэл баримтлалтай танилцаж, үзэл баримтлал болон хуулийн төслийн зорилт, түүнийг хангахад чиглэсэн зохицуулалтуудыг харьцуулах байдлаар дүн шинжилгээ хийлээ. Хуулийн төслийн үзэл баримтлалд:

Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн. Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ. Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.” гэж, Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Улсын Их Хурал төрийн дотоод, гадаад бодлогын аль ч асуудлыг санаачлан хэлэлцэж болох бөгөөд дараахь асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ: 7/ төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлого, үндсэн чиглэлийг тодорхойлж, хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцүүлэн боловсруулсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг батлах; Хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна. Улсын төсвийг хэлэлцэн батлахдаа төсвийн орлого, зарлагын бүтцийг өөрчилж болно. Ингэхдээ Засгийн газрын өргөн мэдүүлсэн төсвийн зарлагын болон алдагдлын хэмжээг нэмэгдүүлж үл болно.” гэж тус тус заасан.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 8 дугаар зүйлд Эдийн засгийн хөгжил, шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого боловсруулж хэрэгжүүлэх талаархи Засгийн газрын бүрэн эрхийг тодорхойлохдоо “1.Монгол Улсын урт

хугацааны хөгжлийн бодлого, Хөгжлийн зорилтот хөтөлбөр, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө болон улсын төсвийг боловсруулахад Засгийн газраас баримтлах үзүүлэлтүүдийн хязгаар, үндсэн тэнцвэрийг тодорхойлсон төсвийн хүрээний мэдэгдлийг Монгол Улсын Үндсэн хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ. 2. Улсын төсвийн төслийг Улсын Их Хурлаас баталсан урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхэд чиглэсэн Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэн боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, гарсан шийдвэрийг хэрэгжүүлнэ. гэж заасан.

Үндсэн хуулийн агуулгаар газрын хэвлийн баялгийн үр өгөөж нь одоо ба ирээдүй үеийн иргэдэд тэгш, шударга хүртээх зорилгоор Үндэсний баялгийн сангаар дамжуулан хуваарилж байхаар, улмаар төсөв нь Монгол Улсын хөгжлийн бодлогод туссан зорилго, зорилтыг санхүүжүүлэхэд чиглэсэн байхыг тодорхой заажээ. Иймээс ч байгалийн шавхагдах нөөц баялгаас нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийг тооцож, түүнийг өнөө болон ирээдүйн иргэдэд хэрхэн үр ашигтай хуваарилах болон зарцуулах асуудал нь төсвийн бодлогын нэг чухал үзүүлэлт болно. Энэ агуулгаар манай улс 2010 оноос төсвийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн байгалийн шавхагдах нөөцийг нэг дор бүрэн дайчлахгүй байх төсвийн тусгай шаардлагыг Төсвийн тогтвортой байдлын хуульд тусгаж, хэрэгжүүлж ирсэн ч 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн хуулийн өөрчлөлтөөр дээрх тусгай шаардлагыг агуулгыг өөрчилж, байгалийн баялгийн үр өгөөжийг зөвхөн өнөө цагт зарцуулах нөхцөлийг бүрдүүлсэн нь Үндсэн хуулийн агуулгатай нийцэхгүй байна.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд заасны дагуу төсвийн хүрээний мэдэгдлийг Монгол Улсын Үндсэн хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу боловсруулах ба уг баримт бичиг нь Засгийн газраас баримтлах үзүүлэлтүүдийн хязгаар, үндсэн тэнцвэрийг тодорхойлсон байхыг заасан байна. Өөрөөр хэлбэл, төсвийн хүрээний мэдэгдэл нь төсвийн орлого, зарлагын бодит тэнцлийг илэрхийлсэн байхыг хууль тогтоомжийн хүрээнд тодорхой дурджээ.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1. "төсвийн тусгай шаардлага" гэж нэгдсэн төсвийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн, төсвийн богино, дунд, урт хугацааны бодлого, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг тодорхойлоход баримтлах, энэ хуулиар тогтоосон зохистой үзүүлэлтийн түвшин, харьцаа, хязгаарлалтыг; гэж заасан.

Мөн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.11. "нэгдсэн төсөв" гэж Төсвийн тухай хуулийн 21.1-т заасныг; Төсвийн тухай хуулийн 21.1. Монгол Улсын нэгдсэн төсөв нь улсын төсөв, орон нутгийн төсөв, Ирээдүйн өв сангийн төсөв, Үндэсний баялгийн сангийн төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвөөс бүрдэнэ. гэж заасан. Дээрх хуулийн зохицуулалтыг нэгтгэн дүгнэвэл, нэгдсэн төсвийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн төсвийн бодлогод баримтлах тусгай шаардлага нь Үндсэн хуульд нийцэх учиртай. Иймээс ч төсвийн тусгай шаардлагыг өөрчилсөн хуулийн өөрчлөлтийг эргэн харж, байгалийн баялгаас хамааралтай хязгааргүй өсөн нэмэгдэх зарлагын өсөлтийг хязгаарлаж, ирээдүйн цагийн иргэдийн боломжийг хамгаалах зайлшгүй хэрэгцээ шаардлагатай байна.

Иймд дээрх үндэслэлээр Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгцээ шаардлагатай байна.

Аливаа хуулийн зохицуулалт нь хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцсэн байх ёстой учраас нэн түрүүнд хуулийн төслийн зорилгыг хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хэрэгцээ шаардлага, үндэслэл болон зорилготой харьцуулан дараах үнэлэх хэсгээ тогтоолоо.

Хуулийн төслийн хэрэгцээ шаардлага	Хуулийн төслийн зорилго
Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг Үндсэн хуульд нийцүүлэх шаардлагатай.	Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зорилго нь нэгдсэн төсвийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн төсвийн тусгай шаардлагыг Үндсэн хуульд нийцүүлэн өөрчилж, байгалийн баялгийг өнөө болон ирээдүйн цагийн иргэдэд, тэгш шударга хүртээхэд чиглэсэн. Өөрөөр хэлбэл, байгалийн баялгийн ашиглалтаас бий болсон орлогыг бүхэлд нь одоо цагт зарцуулахгүйгээр, Үндэсний баялгийн сангаар дамжуулан, ирээдүй хойчдоо үлдээх зарчмыг хэрэгжүүлэхэд оршино.

Хуулийн төслийн зохицуулалтууд нь хуулийн төслийн зорилгыг хангахад чиглэсэн эсэх, тэдгээр нь зорилгыг хангах боломжтой байдлаар томъёологдсон эсэхийг үнэлэхээр хуулийн төслийн зорилгыг сонгож авсан дараах зохицуулалтуудтай харьцуулан дүн шинжилгээ хийлээ.

Хуулийн төслийн 1-3 дугаар зүйлд

<p>1 дүгээр зүйл.Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 12.1.10, 12.1.11 дэх заалт нэмсүгэй:</p> <p>“12.1.10.нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ;</p> <p>12.1.11.нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ;”</p> <p>2 дугаар зүйл.Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.1.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:</p> <p>“6.1.2.нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний 2 хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байх;</p> <p>6.1.3.тухайн жилийн нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь нь тухайн жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн хувь, тухайн жилийн өмнөх дараалсан 12 жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн дунджийн аль ихээс хэтрэхгүй байх.”</p> <p>3 дугаар зүйл.Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг 20... оны ... дүгээр сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.</p>

Уг хуулийн зорилго нь төсвийн тусгай шаардлагыг Үндсэн хуульд нийцүүлж, байгалийн баялгийн үр өгөөжийг өнөө болон ирээдүйн иргэдэд тэгш, шударга хүртээн, төсвийг үр ашигтай зарцуулах нөхцөл бүрдэнэ.

Иймд дээр дурдсан үндэслэл, шаардлагыг харгалзан, холбогдох харилцаанд эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зорилгоор Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж батлуулах нь зүйтэй гэж үзлээ.

3.2. “Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл нь боловсруулалтын хувьд Хууль тогтоомжийн тухай хуулийн 29, 30 дугаар зүйл болон Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг, түүнчлэн хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдүүд хуулийг ойлгож хэрэглэх, хэрэгжүүлэх боломжтой байдлаар боловсруулагдсан эсэхийг шалгахын тулд хуулийн төслийг бүхэлд нь сонгон авлаа.

Д/д	Хуулийн төслөөс ойлгомжгүй байгаа зохицуулалт	Тайлбар	Санал
1.	Байхгүй	Байхгүй	Байхгүй

Түүнчлэн энэхүү шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийг хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад боловсруулсан эсэхийг шалгасан. Үүнд:

Д/д	Шалгах асуулт	Шаардлагыг хангасан эсэх
1.	29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх;	Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын үзэл баримтлалтай нийцэж байна.
2	29.1.2.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	+
3	29.1.3.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Хуулийн төсөл зохицуулах харилцаа, хүрээнээс хальсан зүйл байхгүй
4	29.1.4.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;	Хуулийн төсөлд зөрчилтэй агуулга байхгүй
5	29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Зөрчилтэй заалт байхгүй
6	29.1.6.хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	Тийм заалт тусгагдаагүй
7	29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш	Энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй

	татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	
8	29.1.8. тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журам;	Энэ төрлийн зөрчилтэй заалт тусгагдаагүй
9	29.1.9. шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээ, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох, хасах заалт;	Бусад асуудлаар зөрчилтэй заалт тусгагдаагүй
10	29.1.10. шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх;	Бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль боловсруулсан байна
11	29.1.11. хуулийн төсөл нь хуулийн зорилго гэсэн зүйлтэй байж болох бөгөөд зорилгод тус хуулиар хангахаар зорьж байгаа иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгана.	Хуулийн төсөлд энэ талаар тусгаагүй байна

Хуулийн төслийн хэл зүй, найруулга дараах нийтлэг шаардлага		
1	30.1.1. Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх;	+
2	30.1.2. нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;	Энэ төрлийн зөрчил байхгүй
3	30.1.3. үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;	+
4	30.1.4. хүч оруулсан нэр томъёо хэрэглэхгүй байх;	Тийм нэр томъёо тусгаагүй байна
5	30.1.5. жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.	Энэ төрлийн зөрчилтэй асуудал байхгүй

Хуулийн төслийн тусгасан байдал нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29, 30 дугаар зүйлд нийцсэн байна.

3.3. “Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг аргачлалд тусгасан хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултуудад хариулах замаар уялдаа холбоог тогтоохын тулд хуулийн төслийг бүхэлд нь авч үзэхээр тооцлоо.

Харилцан уялдаа гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн талаар аргачлалын 4.10 дахь заалтад заасан шалгах асуултад хариулах байдлаар үнэлгээг хийлээ:

№	Асуулт	Хариулт	Дүн шинжилгээ
1	Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх	Тийм	төсвийн тусгай шаардлагыг хэрэгжүүлэх нөхцөлийг Үндсэн хуульд нийцүүлснээр Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн "1.1.Энэ хуулийн зорилт нь нэгдсэн төсвийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн төсвийн удирдлагын зарчим, төсвийн тусгай шаардлагыг тогтоох, хэрэгжүүлэх, түүнд хяналт тавихад төрийн байгууллагын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох, эрдэс баялгийн орлогоор нөхөн сэргээгдэх баялаг бүтээх, эдийн засгийн хөгжлийг дэмжих хөрөнгө оруулалт хийх, санхүүгийн хуримтлал бүрдүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино. гэж заасантай нийцэж байна.
2	Хуулийн төслийн "Хууль тогтоомж" гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх	-	Хуулийн төсөлд асуултад дурдсан хэсэг байхгүй болно.
3	Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх	-	Хуулийн төсөлд асуултад дурдсан хэсэг байхгүй болно.
4	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх;	Тийм	Хуулийн төсөлд тусгасан зүйл, хэсэг, заалт нь Үндсэн хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон бусад хуульд заасантай нийцэж байна.
5	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх;	Үгүй	Хуулийн төслийн агуулга нь Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон бусад хуулийн заалттай давхардсан зохицуулалт байхгүй.
6	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх;	Тийм	-

7	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх;	Үгүй	Хуулийн төсөлд зохицуулалт шаардлагатай зохицуулалтыг бүрэн тусгасан.
8	Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх;	Үгүй	Хуулийн төсөлд ийм зохицуулалт байхгүй
9	Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх;	Үгүй	Хуулийн төсөлд ийм зохицуулалт байхгүй
10	Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх;	Үгүй	Хуулийн төсөлд ийм зохицуулалт байхгүй
11	Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх;	Үгүй	Хуулийн төсөлд ийм зохицуулалт байхгүй.
12	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх;	Үгүй	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байна.
13	Хуулийн төслийн зүйл, заалт жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх;	-	Хуулийн төсөлд ийм зохицуулалт байхгүй
14	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Үгүй	Хуулийн төсөлд ийм зохицуулалт байхгүй
15	Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Үгүй	Хуулийн төсөлд ийм зохицуулалт байхгүй
16	Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.	Үгүй	Хуулийн төсөлд тусгагдаагүй.

Энэхүү шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийж үзэхэд хуулийн төслийн зүйл заалт хоорондоо болон Монгол Улсын Үндсэн хууль, хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль, тогтоомжтой давхардсан, зөрчилдсөн зохицуулалт байхгүй байна.

ДӨРӨВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

Энэхүү үнэлгээний ажлын явцад хуулийн төслийн харилцан уялдаа, хуулийн төслийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хуулийн төслийг батлан хэрэгжүүлснээр үүсэж болзошгүй, урьдчилан тооцоогүй үр дагаврыг тодорхойлох зорилгын хүрээнд хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомж, уг асуудлын хүрээнд хийгдсэн судалгааг ашиглан дүн шинжилгээ хийх замаар хийж гүйцэтгэлээ.

Дүгнэлт:

Зорилгод хүрэх байдал: Хуулийн төслийн зүйл, заалтууд нь хуулийн төслийн үзэл баримтлалд дэвшүүлсэн зорилгыг биелүүлэх боломжтой байна гэж үзлээ.

Ойлгомжтой байдал: Хуулийн төсөл нь хуулийн нэр, зүйл, зүйлийн доторх заалт гэсэн бүтэцтэй байгаа нь Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагыг хангасан байна. Хуулийн төслийн тусгасан байдал нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29, 30 дугаар зүйлд нийцсэн байна.

Харилцан уялдаа: Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл нь зүйл заалт хоорондоо болон Монгол Улсын Үндсэн хууль болон хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжтой давхардсан, зөрчилдсөн зохицуулалт агуулаагүй, хуульд заасан шаардлагыг хангасан байна.

Зөвлөмж: Энэхүү хуулийн төсөлд Хууль тогтоомжийн үр нөлөөг тооцох судлах аргачлалын дагуу холбогдох судалгаа хийгдсэн тул энэхүү судалгааны дүгнэлт, зөвлөмжид үндэслэн хуулийн төсөл нь зорилгодоо хүрэх боломжтой, хуулийн төслийг дагаж мөрдөхөд ойлгомжтой, хэрэгжүүлэх боломжтой байх тул батлуулах боломжтой гэж үзэж байна.

-----oOo-----

ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ЗАРДЛЫН ТООЦОО

Удиртгал

Хууль тогтоомжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно” гэж заасны дагуу Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсанаар үйл ажиллагаанд үүсэх зардлыг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”-ын дагуу урьдчилсан байдлаар тооцлоо.

ИРГЭНИЙ ЗАРДАЛ

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар иргэнд санхүүгийн нөлөөлөл үүсэхгүй. Иргэнд төрийн үйлчилгээ авах төлбөр, хураамж гарахгүй.

ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЗАРДАЛ

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар хуулийн этгээдэд санхүүгийн нөлөөлөл үүсэхгүй. Аж ахуй нэгжийн үйл ажиллагааны хувьд нэмэлт орон тоо гарах, шинэ ажлын байрны шаардахгүй, нэмэлт зардал гарахгүй.

УЛСЫН ТӨСӨВТ ҮҮСЭХ ЗАРДАЛ

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор улсын төсвөөс нэмэлт зардал гарахгүй.

-----oOo-----

- ТӨСВИЙН ӨРӨН
- СЭНГЭГЭЙН ӨРӨН
- ЭДНЭГЭЙН ӨРӨН
- ТЭГЭНГЭЙН ӨРӨН

Төсвийн өрөн



УХЖИНЖАВ
Ганзоригийн ТЭМүүлэн

- Боловсруулж буй
- Өргөн баригдсан
- Хэлэлцэх эсэх
- Ажлын хэсэг
- Ажлын хэлэлцүүлэг
- Эцсийн хэлэлцүүлэг
- Батлах

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024.09.12 ӨРӨН

УТГА: ЦААГАР

ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ



Дал

1 дүгээр зүйл. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 12.1.10, 12.1.11 дэх заалт нэмсүгэй:

"12.1.10 нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ;

"12.1.11 нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ."

2 дугаар зүйл. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.1.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"6.1.2 нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний 2 хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байх;

"6.1.3 тухайн жилийн нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь нь тухайн жилийн эрдэс баягийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн хувь, тухайн жилийн өмнөх дараалсан 12 жилийн эрдэс баягийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн дунджийн аль ихээх хэтрэхгүй байх."

3 дугаар зүйл. Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг 20... оны ... дүгээр сарын ...ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ТӨСЛИЙН ФАЙЛУУД

ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ХОЛБОГДУУЛАН САНАЛ АВСАН ТУХАЙ ТЭМДЭГЛЭЛ

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулахтай холбогдуулан Хууль тогтоомжийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.6.1-д заасан “бичгээр санал авах”, 38.6.2-т заасан “уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах” арга хэмжээг хэрэгжүүлж, иргэд, хуулийн этгээд болон холбогдох оролцогчдоос санал авсан болно. Хуулийн төсөл нь төсвийн тогтвортой байдлыг хангах, байгалийн баялгийн үр өгөөжийг өнөө болон ирээдүй үеийн иргэдэд тэгш, шударга хүртээх Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцүүлэх, төсвийн зарлагын өсөлтөд бодит хязгаар тогтоох, хөрөнгийн зардлын зохистой түвшинг хадгалах зорилготой болохыг танилцуулж, оролцогчдын саналыг авсан.

Хуулийн төслийн талаар орон нутагт санал авах уулзалт, хэлэлцүүлгийг Архангай, Өвөрхангай, Баянхонгор аймгуудад зохион байгуулж, тухайн аймгийн иргэд, аж ахуйн нэгж, хуулийн этгээдийн төлөөлөл оролцов. Уулзалтаар төсвийн сахилга, төсвийн зарлагын өсөлтийн хязгаарлалт, байгалийн баялгийн орлогын зохистой хуваарилалт, Үндэсний баялгийн сангийн үр ашиг, орон нутгийн хөгжлийн санхүүжилтийн тогтвортой байдлын талаар хэлэлцэж, оролцогчдоос бичгээр болон амаар санал авч нэгтгэсэн болно.

Хэлэлцүүлэгт оролцогчдын зүгээс төсвийн тусгай шаардлагыг тогтвортой мөрдөх, уул уурхайн орлогын хэт хамаарлыг бууруулах, төсвийн хөрөнгийн зардлыг хөгжлийн бодлоготой уялдуулах, төсвийн ил тод байдлыг нэмэгдүүлэх, орон нутгийн хөгжлийн хэрэгцээтэй уялдсан хөрөнгө оруулалтын бодлого хэрэгжүүлэх шаардлагатай талаар санал гаргасан. Түүнчлэн төсвийн сахилга бат алдагдах нь инфляц, өрийн дарамт, ирээдүй үеийн эдийн засгийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэйг онцолж байв.

Санал авах ажиллагааны дүнд иргэд, хуулийн этгээдийн зүгээс хуулийн төслийн үзэл баримтлал, зорилгыг дэмжиж, төсвийн тогтвортой байдлыг хангах чиглэлээр эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай гэсэн нийтлэг байр суурь илэрхийлсэн болно.

Хүснэгт №1. Хуулийн төсөлтэй холбоотой санал авсан байдал

№	Аймаг	Оролцсон иргэдийн тоо	Уулзалт, хэлэлцүүлэг хийсэн он, сар	Оролцсон хуулийн этгээдийн тоо	Гаргасан саналын тоо	Саналын агуулга
1	Архангай аймаг	1670	2025.07.24 2025.07.25 2025.08.27 2025.09.01 2026.01.25 2026.01.26 2026.01.27 2026.01.29 2026.01.30 2026.02.01 2026.02.08 2026.02.09 2026.02.15	13	21	Төсвийн сахилга батыг сайжруулах, орон нутгийн хөрөнгө оруулалтыг хөгжлийн бодлоготой уялдуулах
2	Өвөрхангай аймаг	967	2026.01.31 2026.03.04 2026.03.05 2026.03.06 2026.03.11 2026.03.12 2026.03.13 2026.03.14 2026.03.14 2026.03.15 2026.03.15 2026.03.15	12	18	Байгалийн баялгийн орлогыг ирээдүй үед хадгалан хуримтлуулах, төсвийн зарлагын өсөлтийг хязгаарлах
3	Баянхонгор аймаг	350	2025.04.14 2026.02.06	8	15	Төсвийн хөрөнгийн зардлын үр ашиг, ил тод байдлыг нэмэгдүүлэх, орон нутгийн санхүүгийн тогтвортой байдлыг хангах
	Нийт	2987		33	54	Төсвийн тогтвортой байдлыг хангах, байгалийн баялгийн үр өгөөжийг тэгш

						хүртээх талаар нийтлэг санал гаргасан
--	--	--	--	--	--	---

Дээрх уулзалт, хэлэлцүүлгийн хүрээнд нийт 2987 иргэн, 33 хуулийн этгээдийн төлөөлөл оролцож, 54 санал гаргасан бөгөөд оролцогчдын дийлэнх нь төсвийн сахилга, төсвийн тусгай шаардлагын хэрэгжилтийг сайжруулах, байгалийн баялгийн орлогыг урт хугацаанд тогтвортой удирдах эрх зүйн зохицуулалтыг дэмжсэн санал илэрхийлсэн болно.



Х.БОЛОРМАА

Х.БУЛГАНТУЯА

Ж.ГАНБААТАР

Г.ГАНБААТАР

П.ГАНЗОРИГ


Х.ГАНХУЯГ

Ц.ДАВААСҮРЭН


Д.ЖАРГАЛСАЙХАН



Б.ЗАЯАБАЛ



Л.МӨНХБААТАР



Л.МӨНХБАЯСГАЛАН

Б.МӨНХСОЁЛ

П.МӨНХТУЛГА


Н.НАРАНБААТАР

Ч.НОМИН



Д.ПҮРЭВДАВАА


П.САЙНЗОРИГ



Б.ТҮВШИН


Д.ҮҮРИЙН ТУЯА

Д.ЦОГТБААТАР



Б.ЧОЙЖИЛСҮРЭН

Д.ЭНХТҮВШИН



Б.ЖАРГАЛАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН ЕРӨНХИЙ
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Л.ӨЛЗИЙСАЙХАН ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ганзоригийн ТЭМҮҮЛЭН

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-29-94, Факс: 32-70-16
E-mail: temuulen@parliament.mn
<http://www.parliament.mn>

2026.05.18 № УИХ-03/5624
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
тов тогтоолгох тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг санаачлан боловсрууллаа.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 40 дүгээр зүйл, 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсэгт заасны дагуу хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх тов тогтоож өгнө үү.

Хавсралт ~~40~~ хуудастай.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



Г.ТЭМҮҮЛЭН

000103



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ганзоригийн ТЭМҮҮЛЭН

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
<http://www.parliament.mn>

2025 02 05 № ВЦХ-03/1642
танай _____-ны № _____-т

┌ Хуулийн төсөлд санал авах тухай ┐

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэгт заасны дагуу Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг санаачлан боловсруулж, уг хуулийн төсөлд холбогдох саналыг авах хүсэлтэй байна.

Иймд уг хуулийн төсөлд Засгийн газрын саналыг авч ирүүлэхийг Танаас хүсье.

Хавсралт 4.3 хуудастай.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН

Г.ТЭМҮҮЛЭН

0000000056

МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 15 дугаар хуралдааны тэмдэглэлд:

“5.ХЭЛЭЛЦСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн санаачлан боловсруулсан Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн санаачлан боловсруулсан Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцээд дараах үндэслэлээр дэмжих боломжгүй саналыг хууль санаачлагчид уламжлахаар тогтов:

1.Монгол Улсын Засгийн газраас эдийн засгийн өсөлтийг дэмжих томоохон төслүүд хэрэгжүүлэх, урсгал зардлын өсөлтийг хязгаарлах зорилгоор нэгдсэн төсвийн зарлага, төсвийн тэнцлийн тусгай шаардлагын бүтэц, агуулгыг олон улсын жишигт нийцүүлэн Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, хуулийг 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдөр Улсын Их Хурал баталсан.

Үүний үр дүнд байнгын шинжтэй, тогтмол гардаг төсвийн урсгал зардлыг эдийн засгийн багтаамжийн тодорхой хувиар хязгаарлаж, эдийн засгийн дунд, урт хугацааны өсөлтийг дэмжих хөгжлийн төслүүдэд хөрөнгө оруулалт хийх төсвийн орон зайг бий болгосон бөгөөд дотоод эдийн засгийн нөөц сууриас бүрдсэн тэнцвэржүүлсэн орлогын эх үүсвэрээр төсвийн зардлыг хязгаарлаж, суурь тэнцлийн ашгийг тооцсоноор уг эх үүсвэрээр өрийн үндсэн төлбөрийг төлж, улмаар төсөвт учрах төлбөрийн ачаалал бууруулж байна.

2.Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд төсвийн тогтвортой байдлыг хангах үүднээс нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар, нэгдсэн төсвийн суурь тэнцлийг төсвийн тэнцвэржүүлсэн орлогоос тооцдог байхаар тус тус заасан. Түүнчлэн, Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу байгалийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн сангаар дамжуулан, одоо ба ирээдүй үеийн иргэдэд тэгш шударга хүртээх зорилгоор Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг баталж, мөн хуулийн 10 дугаар зүйлд төрөлжсөн сангуудын зориулалтыг тодорхойлсон.

Ирээдүйн өв сан нь газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг ирээдүй үеийн иргэн бүрд, Хуримтлалын сан нь одоо үеийн иргэн бүрд тус тус тэгш, шударгаар хүртээх, Хөгжлийн сан нь Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт туссан эдийн засаг, нийгмийн үр өгөөж бүхий хөгжлийн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилготой.


Иймд хуулийн төслийн үзэл баримтлал болон үр нөлөөний үнэлгээнд дурдсан “... байгалийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн сангаар дамжуулан, өнөө болон ирээдүйн иргэдэд тэгш, шударга хүртээх”, “байгалийн

баялгийн ашиглалтаас бий болсон орлогыг зөвхөн одоо цагт зарцуулахгүйгээр, Үндэсний баялгийн сангаар дамжуулан, ирээдүй хойчдоо үлдээх зарчмыг хэрэгжүүлэхэд оршино.” гэсэн зорилго Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн хэрэгжилтэд бүрэн нийцэж, хангагдаж байна.

3.Хуулийн төсөлд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.2 дахь заалтыг “нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний 2 хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байх” гэж өөрчлөн найруулахаар тусгажээ. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.6-д “Энэ хуулийн 6.1.2-т заасан суурь тэнцлийн ашгийг Засгийн газрын өрийн үндсэн төлбөрийг төлж барагдуулахад зарцуулна.” гэж заасан тул хуулийн 6.1.2 дахь заалтыг өөрчилснөөр Засгийн газрын өрийн үндсэн төлбөрийг шинээр өр үүсгэх замаар төлж барагдуулах шаардлага үүсгэх үр дагавартай байна.


Түүнчлэн, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд богино хугацаанд дахин өөрчлөлт оруулж, Засгийн газрын өрийн үндсэн төлбөрийг нэгдсэн төсвийн суурь тэнцлийн ашгаас төлөх зарчмыг өөрчлөх нь олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч байгууллагуудаас Монгол Улсын зээлжих зэрэглэлийг бууруулах эрсдэл үүсгэхээс гадна цаашид олон улсын хөрөнгө оруулагчдын Монгол Улсад итгэх итгэл буурч болзошгүй байна.

Харин хуулийн төсөлд туссан өөрчлөлтүүд нь Үндэсний баялгийн сангийн тухай хуульд заасан төрөлжсөн сангийн эх үүсвэр буюу байгалийн баялгийн хуваарилалтад ямар нэгэн өөрчлөлт оруулах үр дагаваргүй байгааг анхаарах нь зүйтэй байна.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

**БАТЛАВ.
УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН**



Г.ТЭМҮҮЛЭН

2025 оны 2 дугаар сарын 5-ны өдөр

**ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг. Хууль, тогтоолын төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн. Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ. Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.” гэж, мөн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Улсын Их Хурал төрийн дотоод, гадаад бодлогын аль ч асуудлыг санаачлан хэлэлцэж болох бөгөөд дараахь асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ: ...7/ төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлого, үндсэн чиглэлийг тодорхойлж, хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцүүлэн боловсруулсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг батлах; Хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна. Улсын төсвийг хэлэлцэн батлахдаа төсвийн орлого, зарлагын бүтцийг өөрчилж болно. Ингэхдээ Засгийн газрын өргөн мэдүүлсэн төсвийн зарлагын болон алдагдлын хэмжээг нэмэгдүүлж үл болно.” гэж тус тус заасан.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 8 дугаар зүйлд Эдийн засгийн хөгжил, шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого боловсруулж хэрэгжүүлэх талаархи Засгийн газрын бүрэн эрхийг тодорхойлохдоо 8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Хөгжлийн зорилтот хөтөлбөр, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө болон улсын төсвийг боловсруулахад Засгийн газраас баримтлах үзүүлэлтүүдийн хязгаар, үндсэн тэнцвэрийг тодорхойлсон төсвийн хүрээний мэдэгдлийг Монгол Улсын Үндсэн хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.”, мөн хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Улсын төсвийн төслийг Улсын Их Хурлаас баталсан урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхэд чиглэсэн Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэн боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, гарсан шийдвэрийг хэрэгжүүлнэ.” гэж тус тус заасан.

Үндсэн хуулийн агуулгаар газрын хэвлийн баялгийн үр өгөөж нь одоо ба ирээдүй үеийн иргэдэд тэгш, шударга хүртээх зорилгоор Үндэсний баялгийн сангаар дамжуулан хуваарилж байхаар, улмаар төсөв нь Монгол Улсын хөгжлийн бодлогод туссан зорилго, зорилтыг санхүүжүүлэхэд чиглэсэн байхыг тодорхой заажээ. Иймээс ч байгалийн шавхагдах нөөц баялгаас нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийг тооцож, түүнийг өнөө болон ирээдүйн иргэдэд хэрхэн үр ашигтай хуваарилах болон зарцуулах асуудал нь төсвийн бодлогын нэг чухал үзүүлэлт болно. Энэ агуулгаар манай улс 2010 оноос төсвийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн байгалийн шавхагдах нөөцийг нэг дор бүрэн дайчлахгүй байх төсвийн тусгай шаардлагыг Төсвийн тогтвортой байдлын хуульд тусгаж, хэрэгжүүлж ирсэн ч 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн хуулийн өөрчлөлтөөр дээрх тусгай шаардлагыг агуулгыг өөрчилж, байгалийн баялгийн үр өгөөжийг зөвхөн өнөө цагт зарцуулах нөхцөлийг бүрдүүлсэн нь Үндсэн хуулийн агуулгатай нийцэхгүй байна.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд заасны дагуу төсвийн хүрээний мэдэгдлийг Монгол Улсын Үндсэн хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу боловсруулах ба уг баримт бичиг нь Засгийн газраас баримтлах үзүүлэлтүүдийн хязгаар, үндсэн тэнцвэрийг тодорхойлсон байхыг заасан байна. Өөрөөр хэлбэл, төсвийн хүрээний мэдэгдэл нь төсвийн орлого, зарлагын бодит тэнцлийг илэрхийлсэн байхыг хууль тогтоомжийн хүрээнд тодорхой дурджээ.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтад “төсвийн тусгай шаардлага” гэж нэгдсэн төсвийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн, төсвийн богино, дунд, урт хугацааны бодлого, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг тодорхойлоход баримтлах, энэ хуулиар тогтоосон зохистой үзүүлэлтийн түвшин, харьцаа, хязгаарлалтыг;” гэж заасан.

Мөн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.11 дэх заалтад “нэгдсэн төсөв” гэж Төсвийн тухай хуулийн 21.1-т заасныг;”, Төсвийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэгт “Монгол Улсын нэгдсэн төсөв нь улсын төсөв, орон нутгийн төсөв, Ирээдүйн өв сангийн төсөв, Үндэсний баялгийн сангийн төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвөөс бүрдэнэ.” гэж заасан. Дээрх хуулийн зохицуулалтыг нэгтгэн дүгнэвэл, нэгдсэн төсвийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн төсвийн бодлогод баримтлах тусгай шаардлага нь Үндсэн хуульд нийцэх учиртай. Иймээс ч төсвийн тусгай шаардлагыг өөрчилсөн хуулийн өөрчлөлтийг эргэн харж, байгалийн баялгаас хамааралтай хязгааргүй өсөн нэмэгдэх зарлагын өсөлтийг хязгаарлаж, ирээдүйн цагийн иргэдийн боломжийг хамгаалах зайлшгүй хэрэгцээ шаардлагатай байна.

Иймд дээрх үндэслэлээр Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгцээ шаардлагатай байна.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зорилго нь нэгдсэн төсвийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн төсвийн тусгай шаардлагыг Үндсэн хуульд нийцүүлэн өөрчилж, байгалийн баялгийг

өнөө болон ирээдүйн цагийн иргэдэд, тэгш шударга хүртээхэд чиглэсэн. Өөрөөр хэлбэл, байгалийн баялгийн ашиглалтаас бий болсон орлогыг бүхэлд нь одоо цагт зарцуулахгүйгээр, Үндэсний баялгийн сангаар дамжуулан, ирээдүй хойчдоо үлдээх зарчмыг хэрэгжүүлэхэд оршино.

Хуулийн төсөл нь төсвийн тусгай шаардлагыг өөрчлөх, үүнтэй холбогдуулан төсвийн хүрээний мэдэгдлийн үзүүлэлтэд нэмэлт оруулах болон хууль хэрэгжих хугацааг тусгах зэрэг 3 зүйлээс бүрдэнэ.

1 дүгээр зүйлд Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд тусгах нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ, нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээг нэмэлтээр оруулах;

2 дугаар зүйлд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.1.3 дахь заалтуудыг өөрчлөн найруулах;

3 дугаар зүйлд хуулийг дагаж мөрдөх хугацааг тусгасан.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх арга хэмжээний санал

3.1. Эдийн засгийн үр дагаврын хүрээнд

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар төрөөс болон хувь хүн, хуулийн этгээдээс нэмэлт зардал шаардлагагүй. Иймд Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалтад заасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гарах зардлын тооцоог хийх шаардлагагүй. Түүнчлэн төсвийн тусгай шаардлагыг бодитой хэрэгжүүлснээр байгалийн баялгаас хамааралтай төсвийн зарлагын өсөлтийг хязгаарлах, төсвийг үр ашигтай зарцуулах замаар улс орны эдийн засагт эерэг нөлөөлөл үзүүлнэ.

3.2. Нийгмийн үр дагаврын хүрээнд

Хуулийн төсөл батлагдсанаар өнөө болон ирээдүй цагийн иргэдийн байгалийн баялгийн үр өгөөжийг хүртэх эрх, ашиг хамгаалагдаж, төсвийн тогтвортой байх боломж нөхцөл бүрдэх нь нийгмийн хөгжилд эерэг нөлөөлөл үзүүлнэ.

3.3. Хууль зүйн үр дагаврын хүрээнд

Хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан байгалийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн

сангаар дамжуулан, өнөө болон ирээдүй үеийн иргэдэд тэгш, шударга хүртээх зорилго хангагдана.

Дөрөв.Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох хуулийн төслийн талаар

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжид нийцсэн бөгөөд бусад хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагагүй.

ХУУЛЬ САНААЧЛАГЧ

ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3 дахь заалтад заасан “нэгдсэн төсвийн урсгал зарлагын хэмжээ тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний 30 хувиас хэтрэхгүй байх” тухай төсвийн тусгай шаардлагын дагуу байгалийн баялгийн үр өгөөжөөс бий болох тухайн жилийн орлогыг тухайн жилдээ зарцуулах боломжтой байгаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан байгалийн баялгийн үр өгөөжийг өнөө болон ирээдүйн иргэдэд тэгш, шударга хүртээх тухай зохицуулалттай нийцэхгүй байна.

Үндсэн хуулийн агуулгаар газрын хэвлийн баялгийн үр өгөөж нь одоо ба ирээдүй үеийн иргэдэд тэгш, шударга хүртээх зорилгоор Үндэсний баялгийн сангаар дамжуулан хуваарилж байхаар, улмаар төсөв нь Монгол Улсын хөгжлийн бодлогод туссан зорилго, зорилтыг санхүүжүүлэхэд чиглэсэн байхыг тодорхой заажээ. Иймээс ч байгалийн шавхагдах нөөц баялгаас нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийг тооцож, түүнийг өнөө болон ирээдүйн иргэдэд хэрхэн үр ашигтай хуваарилах болон зарцуулах асуудал нь төсвийн бодлогын нэг чухал үзүүлэлт болно. Энэ агуулгаар манай улс 2010 оноос төсвийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн байгалийн шавхагдах нөөцийг нэг дор бүрэн дайчлахгүй байх төсвийн тусгай шаардлагыг Төсвийн тогтвортой байдлын хуульд тусгаж, хэрэгжүүлж ирсэн ч 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн хуулийн өөрчлөлтөөр дээрх тусгай шаардлагыг агуулгыг өөрчилж, байгалийн баялгийн үр өгөөжийг зөвхөн өнөө цагт зарцуулах нөхцөлийг бүрдүүлсэн нь Үндсэн хуулийн агуулгатай нийцэхгүй байна.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд заасны дагуу төсвийн хүрээний мэдэгдлийг Монгол Улсын Үндсэн хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу боловсруулах ба уг баримт бичиг нь Засгийн газраас баримтлах үзүүлэлтүүдийн хязгаар, үндсэн тэнцвэрийг тодорхойлсон байхыг заасан байна. Өөрөөр хэлбэл, төсвийн хүрээний мэдэгдэл нь төсвийн орлого, зарлагын бодит тэнцлийг илэрхийлсэн байхыг хууль тогтоомжийн хүрээнд тодорхой дурджээ.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1."төсвийн тусгай шаардлага" гэж нэгдсэн төсвийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн, төсвийн богино, дунд, урт хугацааны бодлого, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг тодорхойлоход баримтлах, энэ хуулиар тогтоосон зохистой үзүүлэлтийн түвшин, харьцаа, хязгаарлалтыг; гэж заасан

Мөн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.11."нэгдсэн төсөв" гэж Төсвийн тухай хуулийн 21.1-т заасныг; Төсвийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэгт “Монгол Улсын нэгдсэн төсөв нь улсын төсөв, орон нутгийн төсөв, Ирээдүйн өв сангийн төсөв, Үндэсний баялгийн сангийн төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвөөс бүрдэнэ.” гэж заасан. Дээрх хуулийн зохицуулалтыг нэгтгэн дүгнэвэл, нэгдсэн төсвийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн төсвийн бодлогод баримтлах тусгай шаардлага нь Үндсэн хуульд нийцэх учиртай. Иймээс ч төсвийн тусгай шаардлагыг өөрчилсөн хуулийн өөрчлөлтийг эргэн харж, байгалийн баялгаас хамааралтай хязгааргүй өсөн нэмэгдэх зарлагын өсөлтийг хязгаарлаж, ирээдүйн цагийн иргэдийн боломжийг хамгаалах зайлшгүй хэрэгцээ шаардлагатай байна.

Иймд дээрх үндэслэлээр Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

Тус хуулийн төсөлтэй холбоотой Улсын Их Хурлын цахим хуудас D.parliament.mn сайтад байршуулан санал авсан бөгөөд тухайлан санал ирүүлээгүй болно.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар байгалийн баялгаас хамааралтай төсвийн зарлагын өсөлтийг хязгаарлах, төсвийг үр ашигтай зарцуулах замаар улс орны эдийн засагт зэрэг нөлөөлөл үзүүлнэ. Түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуульд заасан байгалийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн сангаар дамжуулан, өнөө болон ирээдүй үеийн иргэдэд тэгш, шударга хүртээх зорилго хангагдана.

---oOo---

ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн. Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ. Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.” гэж, мөн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Улсын Их Хурал төрийн дотоод, гадаад бодлогын аль ч асуудлыг санаачлан хэлэлцэж болох бөгөөд дараахь асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ: ...7/ төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлого, үндсэн чиглэлийг тодорхойлж, хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцүүлэн боловсруулсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг батлах; Хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна. Улсын төсвийг хэлэлцэн батлахдаа төсвийн орлого, зарлагын бүтцийг өөрчилж болно. Ингэхдээ Засгийн газрын өргөн мэдүүлсэн төсвийн зарлагын болон алдагдлын хэмжээг нэмэгдүүлж үл болно.” гэж тус тус заасан.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 8 дугаар зүйлд Эдийн засгийн хөгжил, шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого боловсруулж хэрэгжүүлэх талаархи Засгийн газрын бүрэн эрхийг тодорхойлохдоо 8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Хөгжлийн зорилтот хөтөлбөр, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө болон улсын төсвийг боловсруулахад Засгийн газраас баримтлах үзүүлэлтүүдийн хязгаар, үндсэн тэнцвэрийг тодорхойлсон төсвийн хүрээний мэдэгдлийг Монгол Улсын Үндсэн хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.”, мөн хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Улсын төсвийн төслийг Улсын Их Хурлаас баталсан урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхэд чиглэсэн Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэн боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, гарсан шийдвэрийг хэрэгжүүлнэ.” гэж тус тус заасан.

Үндсэн хуулийн агуулгаар газрын хэвлийн баялгийн үр өгөөж нь одоо ба ирээдүй үеийн иргэдэд тэгш, шударга хүртээх зорилгоор Үндэсний баялгийн сангаар дамжуулан хуваарилж байхаар, улмаар төсөв нь Монгол Улсын хөгжлийн бодлогод туссан зорилго, зорилтыг санхүүжүүлэхэд чиглэсэн байхыг тодорхой заажээ. Иймээс ч байгалийн шавхагдах нөөц баялгаас нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийг тооцож, түүнийг өнөө болон ирээдүйн иргэдэд хэрхэн үр ашигтай хуваарилах болон зарцуулах асуудал нь төсвийн бодлогын нэг чухал үзүүлэлт болно. Энэ агуулгаар манай улс 2010 оноос төсвийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн байгалийн шавхагдах нөөцийг нэг дор бүрэн дайчлахгүй байх төсвийн тусгай шаардлагыг Төсвийн тогтвортой байдлын хуульд тусгаж, хэрэгжүүлж ирсэн ч 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн хуулийн өөрчлөлтөөр дээрх тусгай

шаардлагыг агуулгыг өөрчилж, байгалийн баялгийн үр өгөөжийг зөвхөн өнөө цагт зарцуулах нөхцөлийг бүрдүүлсэн нь Үндсэн хуулийн агуулгатай нийцэхгүй байна.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд заасны дагуу төсвийн хүрээний мэдэгдлийг Монгол Улсын Үндсэн хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу боловсруулах ба уг баримт бичиг нь Засгийн газраас баримтлах үзүүлэлтүүдийн хязгаар, үндсэн тэнцвэрийг тодорхойлсон байхыг заасан байна. Өөрөөр хэлбэл, төсвийн хүрээний мэдэгдэл нь төсвийн орлого, зарлагын бодит тэнцлийг илэрхийлсэн байхыг хууль тогтоомжийн хүрээнд тодорхой дурджээ.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтад ““төсвийн тусгай шаардлага” гэж нэгдсэн төсвийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн, төсвийн богино, дунд, урт хугацааны бодлого, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг тодорхойлоход баримтлах, энэ хуулиар тогтоосон зохистой үзүүлэлтийн түвшин, харьцаа, хязгаарлалтыг;” гэж заасан.

Мөн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.11 дэх заалтад ““нэгдсэн төсөв” гэж Төсвийн тухай хуулийн 21.1-т заасныг;”, Төсвийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэгт “Монгол Улсын нэгдсэн төсөв нь улсын төсөв, орон нутгийн төсөв, Ирээдүйн өв сангийн төсөв, Үндэсний баялгийн сангийн төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвөөс бүрдэнэ.” гэж заасан. Дээрх хуулийн зохицуулалтыг нэгтгэн дүгнэвэл, нэгдсэн төсвийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн төсвийн бодлогод баримтлах тусгай шаардлага нь Үндсэн хуульд нийцэх учиртай. Иймээс ч төсвийн тусгай шаардлагыг өөрчилсөн хуулийн өөрчлөлтийг эргэн харж, байгалийн баялгаас хамааралтай хязгааргүй өсөн нэмэгдэх зарлагын өсөлтийг хязгаарлаж, ирээдүйн цагийн иргэдийн боломжийг хамгаалах зайлшгүй хэрэгцээ шаардлагатай байна.

Иймд дээрх үндэслэлээр Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулсан.

№	Хуулийн төслийн талаар	Зохицуулах харилцааны агуулга, зохицуулалтыг хэрхэн ойлгох	Нэр томьёо, ухагдахууны үүсэл
1	<p>1 дүгээр зүйл.Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 12.1.10, 12.1.11 дэх заалт нэмсүгэй:</p> <p>“12.1.10.нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ; 12.1.11.нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ;”</p>	<p>Эрдэс баялгийн салбарын орлогын хэт өсөлтөөс хамааралгүйгээр эрдэс баялгийн бус салбарын зардлын өсөлтөөс хамаарч нэгдсэн төсвийн зардлын өсөлт, хэмжээг тодорхойлж байхаар төсвийн тусгай шаардлагыг өөрчилөх нь энэ хуулийн төслийн зорилго оршино. Энэ агуулгаар дунд хугацааны төсвийн</p>	<p>Хуулийн төслийн 1 дүгээр зүйлд шинэ нэр томьёо, ухагдахуун тусгагдаагүй</p>

		хүрээний мэдэгдлийн үзүүлэлтэд уг агуулгад нийцүүлж, нэмэлт оруулах шаардлагатай. Өөрөөр хэлбэл, нэгдсэн төсвийн нийт зардлын өсөлт болон нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ нь төсвийн хүрээний үзүүлэлт болгож тооцох шаардлагатай байна.	
2	<p>2 дугаар зүйл.Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.1.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:</p> <p>“6.1.2.нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний 2 хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байх;</p> <p>6.1.3.тухайн жилийн нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь нь тухайн жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн хувь, тухайн жилийн өмнөх дараалсан 12 жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн дунджийн аль ихээс хэтрэхгүй байх.”</p>	<p>Төсвийн тусгай шаардлагыг Үндсэн хуульд нийцүүлэн, эрдэс баялгийн салбарын орлогыг бүхэлд нь зарцуулах боломжийг хязгаарлах шаардлагатай байна. Энэ агуулгаар төсвийн тусгай шаардлагад нэгдсэн төсвийн зардлын өсөлтийг эрдэс баялгийн бус салбарын өсөлттэй уялдуулан өөрчилдөг байхаар хуулийн төсөлд тусгасан.</p> <p>Энэ агуулгаар нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь алдагдалтай байх боломжтой бөгөөд уг алдагдлын хязгаарыг зайлшгүй тогтоох шаардлагатай байна.</p>	Хуулийн төслийн 2 дугаар зүйлд шинэ нэр томьёо, ухагдахуун тусгагдаагүй
3	<p>3 дугаар зүйл.Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг 20... оны ... дүгээр сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.</p>	Хуулийн төслийн хэрэгжих хугацааг тодорхойлсон.	Хуулийн төслийн 3 дугаар зүйлд шинэ нэр томьёо, ухагдахуун тусгагдаагүй

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 12.1.10, 12.1.11 дэх заалт нэмсүгэй:

“12.1.10.нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ;
12.1.11.нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ;”

2 дугаар зүйл.Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.1.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“6.1.2.нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний 2 хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байх;

6.1.3.тухайн жилийн нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь нь тухайн жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн хувь, тухайн жилийн өмнөх дараалсан 12 жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн дунджийн аль ихээс хэтрэхгүй байх.”

3 дугаар зүйл.Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг 20... оны ... дүгээр сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг